

Энэ бэлдмэлийг хэрэглэхийн өмнө зааврыг анхааралтай уншиж танилцана уу. Дахин унших шаардлага гарч мэдэх учир зааврыг хадгалаарай. Нэмэлт мэдээлэл, зөвлөгөөг эмчлэгч эмч, эм зүйчээсээ аваарай.

Эмийн хэрэглээний заавар. Эмчлүүлэгчдэд зориулав

ТИРОЗУР

гель

Найрлага. нэг грам гелд

Үйлчлэгч бодис: Тиротрицин 1 мг

Туслах бодис:

Цетилпиридины хлорид, пропиленгликоль, спирт 96%, карбомер, трометамол, цэвэршүүлсэн ус .

Эмийн хэлбэр: гель

Эмийн эмчилгээний бүлэг: хэсэг газарт хэрэглэх антибиотик

Хэрэглэх заалт

- Тиротрицинд мэдрэг, эмгэг төрөгч бичил биетнээр үүсгэгдсэн супер халдвар бүхий бага зэрэг шүүс гарч байгаа өнгөц шарханд түрхэж хэрэглэнэ.

Хориглох заалт

- Бэлдмэлийн найрлагад орсон аль нэг бодист хэт мэдрэгшилтэй (харшилтай) бол

Эмийн харилцан үйлдэл

Бусад эмийн бэлдмэлүүдтэй харилцан үйлчлэлцсэн тухай мэдээлэл одоогоор байхгүй. Хэрэв та энэ эмээс өмнө ямар нэгэн эмийг түрхэн хэрэглэж байсан бол эмчдээ мэдээлнэ үү

Анхааруулга, сэрэмжлүүлэг

Бэлдмэл нүдэнд орвол хорсгох учраас нүдний ойр орчимдоо түрхэх үедээ болгоомжлохыг сануулж байна.

Тирозур гелийн найрлагад полиэтилгеликоль агуулагддаг учраас арьсыг цочроож болзошгүй.

Энэ бэлдмэл хамрын салстад түрхэж хэрэглэх зориулалтгүй. Ингэж хэрэглээд хамар нь “битүүрч”, үнэрлэх чадваргүй болж байсан тохиолдолд бүртгэгдсэн.



Жирэмсэн ба хөхүүл хүүхэдтэй эхэд, энэ бэлдмэлийг бусад бүх эмийн бэлдмэлүүдийн нэгэн адил эмчээс зөвлөлгөө авч, өгч болох ашигтай үр дүн болоод илэрч болох эрсдлийг сайн тооцсоны дараа хэрэглээрэй.

Энэ бэлдмэлийг аль ч насны хүүхдэд хэрэглэх боломжтой.

Хэрэглэх арга, тун

Гелийг өдөрт 2-3 удаа арьсны гэмтсэн хэсэг дээр нимгэн түрхэж хэрэглэнэ. Бага хэмжээний шарх болон биеийн ил хэсэгт гарсан шархыг заавал боох хэрэггүй. Том хэмжээний шарх болон аниагүй, шүүс ихтэй шархыг боолт хийж хамгаалах ба боолтыг 1-2 хоногийн дотор заавал сольж байх хэрэгтэй.

Эмчилгээг үргэлжлүүлэх хугацаа хүн бүрт адилгүй байна.

Хэрэв 7 хоног хэрэглэсний дараа сайжрал гарахгүй байвал эмчээс зөвлөлгөө авах хэрэгтэй.

Гаж нөлөө

Харшлын урвал үүсч болзошгүй. (арьс хорсох)

Хадгалах хугацаа 3 жил. Бэлдмэлийг нээснээс хойш 3 сар.
Хадгалах хугацаа нь дууссан тохиолдолд хэрэглэхийг хориглоно.

Хадгалах нөхцөл

Тасалгааны 25°C-с ихгүй хэмд хадгална. Хүүхэд хүрэхээргүй газарт хадгал!

Эмийн сангаас олгох нөхцөл Жоргүй олгоно

Эмийн хэлбэр , савлалт

Нэг зөөлөн бортгон саванд гелийг 5г эсвэл 25г хэмжээгээр савлаж, хатуу цаасан хайрцагт хийж хаяглан битүүмжилсэн.

Үйлдвэрлэсэн

Герман улс: 61138 Нидердорфельден, Херцбергштрассе 3

Энгельгард Арцнаймиттель ГмбХ & Ко. КГ.

